

Дарга бөгөөд төргүүлэх аудиторын  
2020 оны 10 дугаар сарын 14.-ийн өдрийн  
10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОЖ БАЙГАА НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧ СОНГУУЛИЙН  
ЗАРДЛЫН ТАЙЛАН ГАРГАХ, ЗАРДЛЫН ТАЙЛАНД АУДИТ ХИХ, ХЯНАХ, ДҮНГ  
НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, ТАНИЛЦУУЛАХ ЖУРАМ

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### Нэг. Журмын зорилго

1.1. Энэ журмын зорилго нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтээ хуулиар хулээн зөвшөөрсөн, бодитой эх үүсвэрээс бурдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан талаар тайлагнах, түүнд дүгнэлт гаргах, сонгуулийн санхүүжилтийг сонгогч иргэн, олон нийтэд нээлттэй, ил тод байлгах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

#### Хоёр. Журмын үйлчлэх хүрээ

2.1. Энэ журмыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн санхүүжилтийн хөрөнгийг хуримтлуулах, сонгуулийн зардал гаргах, сонгуулийн зардлын тайлан гаргах, сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулах, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газраас сонгуулийн зардлын тайланг хянаж, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулахад дагаж мөрднө.

2.2 Энэхүү журам нь тус журмын 16.4-д заасан маягт бүхий хавсралтаас бүрдэнэ.

### ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН САНХҮҮЖИЛТ

#### Гурав. Сонгуулийн зардлын данс

3.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн /цаашид "хууль" гэх/ 50.1-д зааснаар сонгуульд оролцож байгаа нам, эвсэл болон нэр дэвшигч тус бүр аймаг, суманд сонгуулийн зардлын төгрөгийн нэг данстай байна.

3.2. Эвслийг төлөөлөх байгууллагын шийдвэрээр эвсэлд нэгдсэн нэг нам эвслийг төлөөлж эвслийн сонгуулийн зардлын данс нээлгэх ба эвслийг төлөөлөх байгууллагаас эрх олгогдсон этгээд эвслийн сонгуулийн зардлын данснаас зарлага гаргана.

#### Дөрөв. Сонгуулийн зардлын санхүүжилт

4.1. Нам, эвслийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, мөнгөн хандиваас бүрдэнэ.

4.2. Нам, эвслээс нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

4.3. Бие даан нэр дэвшигчийн сонгуулийн санхүүжилт нь нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө, мөнгөн ба мөнгөн бус хандиваас бүрдэнэ.

#### Тав. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө

5.1. Сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгө нь Улс төрийн намын тухай хуульд заасны дагуу намын өөрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө байна.

5.2. Нам энэ журмын 5.1-д заасан хөрөнгийг өөрийн данснаасаа нам, эвслийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэн зарцуулж болно.

5.3. Нам, эвсэл өөрийн нэр дэвшигчийн сонгуулийн зардалд зориулж олгох намын өөрийн хөрөнгийг нам, эвслийн сонгуулийн зардлын данснаас тухайн нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлэг хийж олгоно.

5.4. Нам, эвсэл сонгуулийн зардалд зарцуулах намын өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бурдүүлэхийг хориглоно.

#### **Зургаа. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө**

6.1. Сонгуулийн зардалд зарцуулах нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөд Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан орлогод хамаарах мөнгөн хөрөнгө хамаарна.

6.2. Нэр дэвшигч энэ журмын 6.1-д заасан мөнгөн хөрөнгийг өөрийн данснаасаа сонгуулийн зардлын дансандaa байршуулж зарцуулна.

6.3. Нэр дэвшигч сонгуулийн зардалд зарцуулах өөрийн хөрөнгийг бусдаас бэлэглэл, зээл хэлбэрээр авч бурдүүлэхийг хориглоно.

#### **Долоо. Сонгуулийн хандив**

7.1. Хуулийн 52.1-д зааснаар сонгуулийн хандив нь мөнгөн ба мөнгөн бус хэлбэртэй байна.

7.2. Хандив нь хандивлагчийн өөрийн хөрөнгө, үйл ажиллагааны орлогын чадамжаас даваагүй, бодитой байна.

7.3. Хандивлагч нэг нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгсөн нь өөр нам, эвсэл, нэр дэвшигчид хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.4. Хандивлагч нэр дэвшигчид мөнгөн хандив өгсөн нь тухайн нэр дэвшигчид мөнгөн бус хандив өгөхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

7.5. Хуулийн 55.1-д заасан этгээд хандив өгөхийг хориглох ба нам, эвсэл, нэр дэвшигч шаардсан тохиолдолд хандивлагч нь уг шаардлагыг хангаж байгаа эсэхийг нотлох баримтыг гаргаж өгөх үүрэгтэй.

#### **Найм. Мөнгөн хандив**

8.1. Хандивлагч этгээдээс эргэж төлөх нөхцөлгүйгээр нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг мөнгөн хандив гэнэ.

8.2. Хуулийн 53.1-д заасны дагуу мөнгөн хандив нь иргэний хувьд хоёр сая төгрөг хүртэл, хуулийн этгээдийн хувьд арван сая төгрөг хүртэл байна.

8.3. Нам, эвсэл, нэр дэвшигч нь мөнгөн хандивыг зөвхөн сонгуулийн зардлын дансанд хүлээж авна.

8.4. Нам, эвсэл болон нэр дэвшигч сонгуулийн зардлын данс хооронд шилжүүлсэн мөнгөн хөрөнгийг хандивт тооцохгүй.

#### **Ec. Мөнгөн бус хандив**

9.1. Хандивлагч этгээдээс сонгуулийн сурталчилгаа эхэлсэн өдрөөс дуусах хүртэл хугацаанд зөвхөн нэр дэвшигчид үнэ төлбөргүйгээр үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, үйлчилгээ үзүүлэхийг мөнгөн бус хандив гэнэ.

9.2.Үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх мөнгөн бус хандивын гэрээг тухайн эд хөрөнгийн өмчлөгч, эсхүл түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.3.Үйлчилгээ үзүүлэх мөнгөн бус хандивыг тухайн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдтэй байгуулна.

9.4.Хуулийн 55.5-д заасны дагуу нам өөрийн өмчлөлийн хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаанд ашиглуулж болох бөгөөд энэ нь хандивт тооцогдохгүй.

#### **Арав. Мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлох**

10.1.Мөнгөн бус хандивын зах зээлийн дундаж үнэлгээг дараах журмаар тодорхойлно:

10.1.1.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг бол уг үйл ажиллагааны дундаж үнэлгээгээр;

10.1.2.тухайн эд хөрөнгө ашиглуулсан, эзэмшүүлсэн, үйлчилгээ үзүүлсэн хандивлагч энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагааг эрхэлдэггүй бол тухайн газар нутаг дахь энэ төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн үнийн дундаж үнэлгээгээр.

10.2.Мөнгөн бус хандивын үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгч болох мөнгөн хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна.

#### **Арван нэг. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив**

11.1.Дараах хандивыг хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивт тооцно:

11.1.1.банкны гүйлгээний баримтад хандивлагчийн нэр, регистрийн дугаар болон хандивын эх үүсвэрийн талаарх мэдээлэл бүрэн тусгагдаагүй мөнгөн хандив;

11.1.2.буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив;

11.1.3.хандив өгөхийг хориглосон этгээдээс өгсөн мөнгөн ба мөнгөн бус хандив;

11.1.4.хуульд заасан хэмжээнээс хэтэрсэн мөнгөн ба мөнгөн бус хандив.

11.2.Нам, эвсэл, нэр дэвшигчид хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг хүлээн авч, зарцуулах, ашиглахыг хориглоно.

**Тайлбар:** Буцах хаяг тодорхойгүй мөнгөн хандив гэдэгт хандивлагчийн нэр, регистрийн дугаар, банкны дансны дугаар зэрэг мэдээлэл зөрүүтэй байхыг хамруулж ойлгоно.

#### **Арван хоёр. Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг буцаах, улсын орлогод шилжүүлэх**

12.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй хандивыг дараах журмаар буцаан шилжүүлэх буюу улсын орлого болгоно:

12.1.1.энэ журмын 11.1.1, 11.1.3-т заасан мөнгөн хандивыг сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргахаас өмнө хандивлагч этгээдэд буцаан шилжүүлэх;

12.1.2.энэ журмын 12.1.1-д заасан хугацаанд буцаан шилжүүлээгүй болон энэ журмын 11.1.2-т заасан мөнгөн хандивыг улсын орлого болгох;

12.1.3.энэ журмын 11.1.4-т заасан хандивыг улсын орлого болгох.

12.2.Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1-д заасны дагуу улсын орлого болгох хандивыг улсын төсвийн орлогын нэгдсэн дансанд тушаана.

**Арван гурав. Хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг ашигласанд тооцох**

13.1.Нам, эвсэл, нэр дэвшигч хуулиар зөвшөөрөгдөөгүй мөнгөн хандивыг сонгуулийн зардлын дансанд хүлээн авснаас хойших сонгуулийн зардлын дансны үлдэгдэл нь уг мөнгөн хандивын хэмжээнээс бага байж болохгүй.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДАЛ**

**Арван дөрөв. Сонгуулийн зардлын ангилал**

14.1.Сонгуулийн зардлыг нам, эвсэл болон нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлалд заасан үзүүлэлтийг харгалзан ангилна.

14.2.Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлыг дараах байдлаар ангилж, тайлagnана:

14.2.1.сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, тараах зардал;

14.2.2.нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал;

14.2.3.намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал;

14.2.4.сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал;

14.2.5.сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал:

14.2.5.а.нэр дэвшигчийн ухуулах байрны түрээсийн зардал;

14.2.5.б.нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах хөлс, урамшууллын зардал;

14.2.5.в.нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах тээврийн хэрэгслийн зардал;

14.2.5.г.нам, эвслээс зарцуулах томилолтын зардал;

14.2.5.д.сонгуулийн сурталчилгаанд зарцуулах бусад зардал.

14.2.6.сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал;

14.2.7.сонгуулийн сурталчилгаанд цахим орчин ашиглах зардал;

14.2.8.өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал нийтлүүлэх зардал;

14.2.9.энэ журмын 14.2.1-14.2.8-д хамаarahгүй бусад зардал.

**Арван тав. Сонгуулийн зардал гаргах**

15.1.Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэсэн өдрөөс эхэлж, сонгуулийн зардлын эцсийн тайлан гаргах хүртэл хугацаанд энэ журмын 14.2-т заасан сонгуулийн зардалд зориулан сонгуулийн зардлын данснаас дансанд шилжүүлэх хэлбэрээр зарлага гаргана.

15.2.Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данснаас гаргасан зарлага тус бүрийн зориулалт нь хүчин төгөлдөр анхан шатны баримтаар нотлогдсон байна.

15.3. Нам, эвсэл, нэр дэвшигчид сонгуулийн зардлын данснаас бэлнээр зарлага гаргахыг хориглоно.

15.4. Дараах зардлын нийт дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй:

15.4.1. сонгуулийн зардлын данснаас зарлага болгосон энэ журмын 14.2-т заасан зардлын дүн;

15.4.2. сонгуулийн зардалтай холбоотой өр төлбөрийн дүн;

15.4.3. мөнгөн бус хандивын хэмжээ /энэ заалт нь зөвхөн нэр дэвшигчид хамаарна/.

15.5. Энэ журмын 15.4-т заасан зардлын дүн нь сонгуулийн зардлын дээд хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд илүү гарсан хэсэгтэй тэнцэх хэмжээний мөнгөн төлбөрийг нам, эвсэл, нэр дэвшигч улсын орлого болгоно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАН**

### **Арван зургаа. Сонгуулийн зардлын тайлан**

16.1. Сонгуулийн зардлын тайланг мөнгөн ба мөнгөн бус гэж ангилна.

16.2. Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн зардлын тайлан гаргана.

16.3. Сонгуулийн зардлын тайланда нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуульд зарцуулсан хөрөнгийн эх үүсвэр ба зарлагын мэдээллийг бүрэн тусгана.

16.4. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах Маягт (1-9)-ын дагуу гаргаж, Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

### **Арван долоо. Сонгуулийн зардлын тайланг нийтэд мэдээлэх**

17.1. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг дараах хэлбэрээр нийтэд мэдээлнэ:

17.1.1. хуулийн 46.1.1, 46.1.2-т заасан цахим хуудаст байршуулах;

17.1.2. өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд байршуулах;

17.1.3. мэдээллийн сайт болон бусад олон нийтийн сүлжээнд байршуулах.

17.2. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын нам, эвсэл болон нэр дэвшигчээс ирүүлсэн сонгуулийн зардлын явцын тайланг хүлээн авмагц өөрийн цахим хуудаст байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын явцын тайланг ирүүлээгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

### **Арван найм. Сонгуулийн зардлын тайлан гаргах**

18.1. Хуулийн 56.3-т заасны дагуу нам, эвсэл санал авах өдрөөс хойш 45 хоногт, нэр дэвшигч санал авах өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайландаа хувийн аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

18.2. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 18.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх сонгуулийн зардлын тайландаа дараах баримт бичгүүдийг хавсаргасан байна:

18.2.1. сонгуулийн зардлын дансны хуулга;

18.2.2. сонгуулийн зардлын тайланда тусгасан орлого, зарлагыг нотлох анхан шатны баримт;

18.2.3. байгуулсан гэрээ, хэлцлийн хуулбар;

18.2.4. нэр дэвшигч мөнгөн бус хандив авсан бол хандивын гэрээний хуулбар, хандивын гэрээний үнэлгээг тодорхойлсон нотлох баримт.

#### **Арван ес. Сонгуулийн зардлын тайланг нийтэд мэдээлэх**

19.1. Нам, эвсэл, нэр дэвшигч аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулсан сонгуулийн зардлын тайланг энэ журмын 17.1-д заасан хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

19.2. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар энэ журмын 19.1-д заасны дагуу ирүүлсэн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг цахим хуудастаа байршуулж, хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайланг ирүүлээгүй нам, эсвэл, нэр дэвшигчийг нийтэд мэдээлнэ.

#### **Хорь. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар сонгуулийн зардлын тайланг хянах, дүнг мэдээлэх**

20.1. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар энэ журмын 18.1-д заасны дагуу ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ.

20.2. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар сонгуулийн зардлын эцсийн тайланг хянахдаа хуулийн 57.2.2-57.2.4-т заасан болон Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

20.3. Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар энэ журмын 20.2-т заасан бүрэн эрхийн дагуу мэдээлэл, баримт шаардсан тохиолдолд холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч, бусад иргэн, хуулийн этгээд мэдээлэл, баримтыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

20.4. Нам, эвсэл, нэр дэвшигч энэ журмын 12.1, 15.5-д заасан мөнгөн хөрөнгийг улсын орлого болгоогүй тохиолдолд уг зөрчлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газар холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.

#### **Хорин нэг. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланда дүгнэлт гаргах**

21.1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланда аудит хийх аудитын хуулийн этгээд нь Аудитын тухай хуульд заасны дагуу ажил төрөл, хувийн харилцаа холбоо, ашиг сонирхлын хувьд нам, эвсэл, нэр дэвшигчээс хараат бус байх шаардлагыг хангасан байна.

21.2. Сонгуулийн зардлын тайланда аудит хийхээр нам, эвсэл, нэр дэвшигчтэй гэрээ байгуулсан аудитын хуулийн этгээд нь энэ журмын 21.1-д заасан нөхцөл байдал үүсээгүй талаарх мэдэгдэл, тайлбараа гэрээ байгуулснаас хойш 2 хоногийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт мэдэгдэнэ.

21.3. Аудитын хуулийн этгээд энэ журмын 21.2-т заасны дагуу гэрээ байгуулснаас хойш аливаа шалтгаанаар сонгуулийн зардлын тайланда аудит хийгээгүй, аудит хийхээс татгалзсан тохиолдолд энэ тухай мэдэгдэл, тайлбараа 2 хоногийн дотор Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ.

21.4. Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайланда хийх аудитыг тухайн нам, эвсэл, нэр дэвшигчээс энэ журмын 16.4-д заасан маягтын дагуу гаргасан тайлан, энэ журмын 18.2-т заасан баримт бичиг болон анхан шатны баримтад үндэслэн хийнэ.

21.5.Холбогдох нам, эвсэл, нэр дэвшигч нь аудитын хуулийн этгээдээс шаардсан баримт бичиг, мэдээллийг тогтоосон хугацаанд гаргаж өгөх, эсхүл гуравдагч этгээдээс гаргуулж өгөх, аудитын үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоогоор хангах үүрэгтэй.

21.6.Аудитын хуулийн этгээд дараах асуудлуудын хүрээнд сонгуулийн зардлын тайландаудийн аудит хийж дүгнэлт гаргана:

21.6.1.сонгуулийн зардлын тайланг батлагдсан маягтын дагуу иж бүрэн гаргаж, баталгаажуулсан эсэх;

21.6.2.сонгуулийн зардалд зарцуулсан намын болон нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийн эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

21.6.3.хүлээн авсан мөнгөн хандив нь хуулиар зөвшөөрөгдсөн, эх үүсвэр нь тодорхой, бодитой эсэх;

21.6.4.хүлээн авсан мөнгөн бус хандивын үнэлгээг бодитой тодорхойлсон эсэх;

21.6.5.сонгуулийн зардлын тайландаудийн тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв тусгагдсан эсэх;

21.6.6.сонгуулийн зардлын зарцуулалт зориулалтын дагуу бодитой хийгдсэн бөгөөд анхан шатны баримтыг үндэслэн сонгуулийн зардлын тайландауд үнэн зөв тусгагдсан эсэх.

21.7.Аудитын хуулийн этгээд сонгуулийн зардлын тайландаудийн аудит хийхдээ Аудитын олон улсын стандартыг баримталж, Аудитын олон улсын стандарт 800 “Тусгай зорилго бүхий үзэл баримтлалд нийцүүлэн бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит”-г удирдлага болгон стандартын дагуу дүгнэлт гаргана.

21.8.Аудитын хуулийн этгээд аудитын үр дүн болон энэ журмын 21.7-д заасан дүгнэлтэд дэмжлэг болгох зорилгоор дараах бүтэц, агуулга бүхий аудитын дэлгэрэнгүй тайлан, дүгнэлтийн хамт Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ:

21.8.1.аудит хийсэн үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

21.8.2.аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт;

21.8.3.тодорхойлсон эрсдэл, түүнийг үндэслэн байдал;

21.8.4.материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар;

21.8.5.аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн;

21.8.6.илрүүлсэн зүйлсийн нэгтгэл, тайлбар;

21.8.7.санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.

## ТАВДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗААЛТ

**Хорин хоёр. Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллагын оролцоо**

22.1.Сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллага дараах оролцоотой байна:

22.1.1.сонгуулийн зардлын ил тод байдлыг хангахад чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавихад оролцох, хөндлөнгийн ажиглалт хийх;

22.1.2.сонгуулийн зардалтай холбоотой гарсан зөрчил, гэмт хэргийн шинжтэй үйлдлийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагад гомдол, мэдээлэл гаргах;

22.1.3. нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайланг үнэн зөв, бодитой гаргасан эсэх талаар дүн шинжилгээ хийх, санал, зөвлөмж гаргах.

-----oOo-----

Дарга бөгөөд тэргүүлэх аудиторын  
2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн  
10 дугаар тушаалтын хоёрдугаар хавсралт

НАМЫН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

8247144139 Маягт-1-1  
ДБА0060 9018301  
... оны ...-р сарын ...-ны өдөр

Тайлан ирүүлсэн огноо:

**НЭГ. НАМЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Намын нэр:

\_\_\_\_\_

Регистрийн дугаар:

\_\_\_\_\_

Нэр дэвшиүүлсэн хүний тоо:

\_\_\_\_\_

**ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:

\_\_\_\_\_

Дансны дугаар:

\_\_\_\_\_

Гүйлгээ хийж эхэлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Эхний үлдэгдэл:

\_\_\_\_\_

**ГУРАВ. НАМЫН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

Үзүүлэлт	Дүн /төгрөгөөр/	Тоо
<b>1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>		
1.1 Намын өөрийн хөрөнгө		
1.2 Хуулийн этгээдийн хандив		
1.3 Иргэний хандив		
<b>2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>		
2.1 Сонгуулийн зардал		
2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
2.1.2 нийтийн эзэмшилийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал		
2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал		
2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		

2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	
2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	
2.1.7 цахим орчин ашиглах зардал	
2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	8217144139 ДЛОА0060 9016301
2.2 Бусад зардлын дүн	
<b>3. ҮЛДЭГДЭЛ</b>	
<b>4. ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ</b>	
<b>5. ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР</b>	
<b>6. ХУУЛИАР ЗЭВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ</b>	
6.1 буцаасан хандив	
6.2 улсын орлого болгосон хандив	
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)	

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: / Овог нэр /

/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН: / Овог нэр /

/ Албан тушаал /

# ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Маягт-1-2

Тайлан ирүүлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

## НЭГ. ЭВСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эвслийн нэр:

\_\_\_\_\_

8217111153  
ДОДДОРЖСҮРЭН

Эвсэлд нэгдсэн намын тоо:

\_\_\_\_\_

Нэр дэвшүүлсэн хүний тоо:

\_\_\_\_\_

## ХОЁР. ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Сонгуулийн зардлын данс нээлгэсэн банкны нэр:

\_\_\_\_\_

Дансны дугаар:

\_\_\_\_\_

Гүйлгээ хийж эхэлсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Хамгийн сүүлд гүйлгээ хийсэн огноо:

... оны ...-р сарын ...-ны өдөр

Эхний үлдэгдэл:

\_\_\_\_\_

## ГУРАВ. ЭВСЛИЙН СОНГУУЛИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт		Дүн /төгрөгөөр/	Тоо
<b>1. НИЙТ ОРЛОГЫН ДҮН</b>			
1.1 Намуудаас оруулсан өөрийн хөрөнгө			
	Нам 1 /нэр/		
	Нам 2 /нэр/		
	Нам 3 /нэр/		
1.2 Хуулийн этгээдийн хандив			
1.3 Иргэний хандив			
<b>2. НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>			
2.1 Сонгуулийн зардал			
	2.1.1 сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах		
	2.1.2 нийтийн эзэмшилийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зураат самбар, дэлгэц байрлуулах зардал		
	2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдээ, уриа ашиалах зардал		
	2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал		
	2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал		

	2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	
	2.1.7 цахим орчин ашиглах зардал	
	2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэргүүлд материал нийтлүүлэх зардал	
	2.2 Бусад зардлын дүн	
3.	ҮЛДЭГДЭЛ	
4.	ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ	
5.	ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР	
6.	ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ	
6.1	буцаасан хандив	
6.2	улсын орлого болгосон хандив	
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН: / Овог нэр /

/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН: / Овог нэр /

/ Албан тушаал /

	2.1.2 нийтийн эзэмшилийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар, дэлгэц байрлуулах зардал	
	2.1.3 намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардал	
	2.1.4 сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх зардал	8217144139 ДЮА0060 9018301
	2.1.5 сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал	
	2.1.6 сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах	
	2.1.7 цахим орчин ашиглах зардал	
	2.1.8 өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд материал нийтлүүлэх зардал	
2.2	Бусад зардлын дүн	
3.	ҮЛДЭГДЭЛ	
4.	ҮЛДЭГДЛИЙН БАЙРШИЛ	
5.	ТӨЛӨГДӨӨГҮЙ БАЙГАА ӨР ТӨЛБӨР	
6.	ХУУЛИАР ЗЭВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВ	
6.1	буцаасан хандив	
6.2	улсын орлого болгосон хандив	
(Анхаарах: Дээрх бүх мэдээлэл дансны хуулгаар баталгаажна)		

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

/ Овог нэр /

/ Албан тушаал /

ТАЙЛАН ХЯНАСАН:

/ Овог нэр /

/ Албан тушаал /

# НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ТАЙЛАН

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_



/Маягт-2/

№	Дансны дугаар, банкны нэр	Мөнгөн дүн	Огноо	Эх үүсвэр 8217144939 ДЮА0060 99188011
1				
2				
3				
Нийт дүн				

**Заавар:** Мөнгөн дүн, огноо, эх үүсвэрийг гүйлгээ тус бүрээр нэг бүрчлэн бичнэ. Нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа төвлөрүүлсэн нам, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгийг ямар эх үүсвэрээс бүрдүүлсэн талаараа үнэн зөв, тодорхой бичнэ.

Тайлан бэлтгэсэн: /овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан: /овог, нэр/

/албан тушаал /

**МОНГӨН ХАНДИВЫН ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

/Маягт-3/

№	Хандивлагч		Хандивын хэмжээ /төгрөг/	Хандивын эх үүсвэр*	Хандивласан огноо
	Нэр	Регистрийн дугаар			
1					
2					
3					
		Дүн			
1					
2					
3					
		Дүн			
	Нийт дүн				

\*Хандивын эх үүсвэрийн мэдээллийг зөвхөн банкны гүйлгээний баримтад тусгагдсан байдлаар бичнэ.

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

## МӨНГӨН БУС ХАНДИВЫН ТАЙЛАН

Нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_



/Маягт-4/

№	Хандивлагч		Хандивлаг чийн хаяг	Эд хөрөнгө болон авсан үйлчилгээний мэдээлэл, хандивын зориулалт*	Гэрээний дугаар	Хандивын хэмжээ /хандивын гэрээнд зааснаар/	ОГНОО
	Нэр	Регистрийн дугаар					
1	Иргэн						
2							
3							
		Дүн					
1	Хуулийн эзгээл						
2							
3							
		Дүн					
	Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/ /албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/ /албан

тушаал/

\*Эзэмшүүлсэн, ашиглаулсан эд хөрөнгө нь үл хөдлөх эд хөрөнгө тохиолдолд улсын бүртгэлийн дугаар, тээврийн хэрэгсэл тохиолдолд улсын дугаар, бусад хөдлөх эд хөрөнгө тохиолдолд хөрөнгийн марк, нэр, эд хөрөнгө эзэмшсэн, ашигласан, авсан үйлчилгээний зориулалтыг тодорхой бичнэ.

### Мөнгөн бус хандивын хэмжээг тодорхойлох жишээ:


- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэггүй этгээд дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр ашиглаулжээ. Энэ тохиолдолд нэр дэвшигч тухайн орон нутаг дахь ийм төрлийн үйл ажиллагаа явуулдаг этгээдээс уз тоног төхөөрөмжийг ашиглахад ямар хэлс төлөхийг судлаар мөнгөн бус хандивын үнэлгээг тодорхойлно.
- Оффисын тоног төхөөрөмж түрээслэх бизнес эрхэлдэг этгээд нэр дэвшигчид сонгуулийн сурталчилгааны ажилд нь хувилагч машин үнэ төлбөргүйгээр

ашиглуулсан тохиолдолд уг мөнгөн бус хандивын хэмжээг тухайн этгээд эх  
төрлийн үйлчилгээ үзүүлээд аёдаг хөлсний дундаж үнэлгээгээр тодорхойлно.



## ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫН ТАЙЛАН

Нам /эвсэл/ нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_



No	Хандивлаг ч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчийн регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивын хэмжээ	Хандивын хэлбэр	Огноо	Хуулиар зөвшөөрөгдөөгүй хандив гэж үзсэн тухай тайлбар
1						
2						
3						
Нийт дүн						

Тайлан бэлтгэсэн: /овог, нэр/


/албан тушаал/

Тайлан хянасан: /овог, нэр/

/албан тушаал/

**ХУУЛИАР ЗӨВШӨӨРӨГДӨӨГҮЙ ХАНДИВЫГ БУЦААСАН БЮОУ УЛСЫН ОРЛОГО  
БОЛГОСОН ТУХАЙ ТАЙЛАН**

Нам /эвсэл/ нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_



№	Хандивлаг ч иргэн, хуулийн этгээдийн нэр /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивлагчий н регистрийн дугаар /хэрэв мэдэгдэж байгаа бол/	Хандивы н хэмжээ	Шилжүүлгийн мэдээлэл		Буцааса н, улсын орлого болгосо н тайлбар	Огно о
				Буцааса н	Улсын орлого болгосо н		
1							
2							
3							
Нийт дүн							

Тайлан бэлтгэсэн:

/овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан:

/овог, нэр/

/албан тушаал /

3					
Нийт дүн					

Тайлан бэлтгэсэн: /овог, нэр/

/албан тушаал/

Тайлан хянасан: /овог, нэр/

/албан тушаал /

**СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДАНСНЫ ГҮЙЛГЭЭ ТУС БҮРЭЭР ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН**

Нам / эвсэл / нэр дэвшигчийн нэр \_\_\_\_\_

Баримтын			Харилцагчийн			Гүйлгээний			Нэм/эвслээс оруулсан			Хүнээс: Орлогын ангилаал			Тайлбар		
№	Огноо	Нэр	Дугаар	Нэр	Гүйлгээний	Утга	Дүн	мөнгөн хөрөнгө			Нэр дэвшигчийн өөрийн			Иргэний	Хуулийн	Хандивын	Маят-8/
								хандив			өгсөн нийт						
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	Банкны үйлчилгээ
																	Бусад
																	Дүн

Дүн																

Тайлан гаргасан:

Хянааж баталгаажуулсан:

Нам, эвсэл, нэр дэвшигчийн нэр, гарын үсэг, тамга

Аудитын хуулийн этгээдийн нэр, гарын үсэг, тамга

